



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/439

Мөрөн сум

Хүүхдийн чөлөөт цагийг үр ашигтай
өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүүхдийн эрхийн тухай Конвенцийн 6 дугаар зүйлийн 2, 29 дүгээр зүйлийн 1-ийн "b", 31 дүгээр зүйлийн 1,2 дахь хэсгүүд, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.5, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Нэгдүгээрт хүүхэд" Хөвсгөл аймгийн хүүхдийн XI чуулганаас гарсан шийдвэр зөвшилцөх бичгийг хэрэгжүүлэх зорилгоор ерөнхий боловсролын сургуулиудын спорт заалыг хүүхдүүдэд хичээлийн бус цагаар үнэ төлбөргүй, нээлттэй ашиглуулах, чөлөөт цагийг нь үр ашигтай өнгөрүүлэх, хүүхдийн уралдаан тэмцээний үед заалыг нээлттэй байлгах орчин нөхцөлийг бүрдүүлсүгэй.

2. Сургуулийн спорт заалыг насанд хүрэгчид, бусад байгууллагуудад төлбөртэй ашиглуулдаг үйл ажиллагааг зогсоож, тусгай хуваарь, дэг гарган 2022 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс хэрэгжүүлж эхлэхийг ерөнхий боловсролын сургуулийн захирлуудад үүрэг болгосугай.

3. Дээрх зорилго, чиглэл ерөнхий боловсролын сургуулиудад хэрэгжиж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж, гүйцэтгэл үр дүнг сар бүр танилцуулж ажиллахыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын дарга (Ц.Ганзориг), аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга (Ч.Дашбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Спорт зааланд чөлөөт цагаа өнгөрөөхдөө дэгийг баримталж, эд хогшил, техник, тоног төхөөрөмжид ариг гамтай хандаж, үйл ажиллагаанд хамрагдах үедээ өөрийгөө болон бусад хүүхдийг эрсдэлт нөхцөлд өртөхөөс урьдчилан сэргийлж байхыг нийт хүүхдүүдэд уриалж, энэхүү шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, анхаарах асуудлыг тухай бүр аймгийн Хүүхдийн төлөө зөвлөлийн ажлын алба Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт мэдэгдэж, зохих арга хэмжээг авахуулж, үр дүнтэй хамтран ажиллахыг аймгийн Хүүхдийн зөвлөл (Х.Туяа)-д даалгасугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Цэцэгмаа)-д даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

6711011037